



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 556

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх Ухааны Академийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 4,626,900.00 (дөрвөн сая зургаан зуун хорин зургаан мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг худалдах хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Шинжлэх Ухааны Академийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн захирал Я.Адъяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002541



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн  
 556 дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх Ухааны Академийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
 акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Хуримтлагдсан элэгдэл		Үлдэгдэл өртөг	Акталж, элбэгээр худалданаас олох орлогын доод хэмжээ
				Балансын үнэ	/төгрөг/		
1	Мицубиши Галант, УБЭ 02-57, суудлын, хөдөлгүүр: 6L11-M5585	1993/2002	326000	3,000,000.00	3,000,000.00	-	100,000.00
2	Бага оврын трактор (Taishin-18)	2006/2014	0	1,626,900.00	1,626,900.00		50,000.00
<b>Нийт дүн</b>				<b>4,626,900.00</b>	<b>4,626,900.00</b>	<b>-</b>	<b>150,000.00</b>
				(дөрвөн сая зургаан зуун хорин зургаан мянга есөн зуун)			(нэг зуун тавин мянга)